

Толгойгоороо бичсэн нь үсэг

Зүрхнээсээ бичсэн нь шүлэг

Амьсгалаар бичсэн нь амь

“Сонсох чихтэй нь сонсогтун”

Харах нүд таньд бий юү?

Сонсох чих таньд бий юү?

Ойлгох зүрх таньд бий юү?

1 Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ.

2 Төрөх хийгээд үхэх цаг, Тариалах хийгээд тарьснаа хураах цаг,

3 Алах хийгээд анагаах цаг, Нураах хийгээд босгох цаг,

4 Уйлах хийгээд инээх цаг, Гашиудах хийгээд бүжиглэх цаг,

5 Чулууг шидэх хийгээд цуглуулах цаг, Тэврэх хийгээд тэврэлтээс зугтах цаг,

6 Эрж олох хийгээд алдаж асгах цаг, Хадгалах хийгээд хаях цаг,

7 Урах хийгээд оёх цаг, Дуугүй байх хийгээд ярих цаг,

8 Хайрлах хийгээд үзэн ядах цаг, Дайтах хийгээд найрамдах цаг байдаг ажээ.

9 Хийж байгаа хөдөлмөрөөс нь ажил хийгчид ямар ашиг байна вэ?

10 Бурханаас миний хэвгүүдэд өгсөн шаналгаат хөдөлмөрийн зовлонтойг би харсан.

11 Бүх юмыг Тэр тухайн цагт нь сайн сайхнаар бүтээсэн бөгөөд хэдийгээр хүн Бурханы үйлдсэн ажлыг эхнээс эцсийг нь хүртэл ойлгохгүй ч гэсэн Тэр тэдний зүрхэнд үүрд мөнхийг байгуулсан билээ. (НОМЛОГЧИЙН ҮГС 3:1 - 11)

1

Таны амь сүнс хэр үнэтэй вэ?

———— Заавар:

Бурханы үгийг уншиж байхдаа өөрт төрсөн бодлоо дээрх зайд бичнэ үү

ТАНЫ АМЬ СҮНС ХЭР ҮНЭТЭЙ ВЭ ?

БУРХАН БИДНИЙ АМИНД ЯАГААД ИХ АНХААРДАГ ВЭ?

26 Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх билээ? (МАТАЙ 16:26)

33 Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно. (МАТАЙ 6:33)

ЭЦСИЙН АМЬСГАЛ БОЛ СҮНСНИЙХ БИШ БИЕ МАХБОДИЙН ҮХЭЛ ЮМ.

2 Газрын шороонд булагдсан нойрсогчдоос олон нь сэрж, нэг хэсэг нь мөнх амь уруу, харин нөгөө хэсэг нь ичгүүр болон мөнхийн жигшил уруу явна.

3 Хэрсүү ухаантай нь тэнгэрийн мандлын гэрэл шиг туяарч, олныг зөв шударга байдалд авчрагчид нь од мэт үүрд мөнх гэрэлтэх болно. (ДАНИЕЛ 12:2 – 3)

19 Таны үхэгсэд амилж, тэдний цогцос босно. Тоосонд хэвтэгчид ээ! Бос, баярлан хашхирагтун. Таны шүүдэр нь гэрлүүдийн шүүдэр мэт билээ. Газар нь сүнс сүгүүдийг гаргана. (ИСАИА 26:19)

13 Тэнгис дотроо байсан үхэгсдийг гаргаж өгөв. Үхэл ба Үхэгсдийн оронөөрсдийн доторх үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэг бүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв. (ИЛЧЛЭЛТ 20:13)

ҮСГИЙГ СҮНСЭЭР ХЭРХЭН УНШИХЫГ ТА МЭДЭХ ҮҮ?

4 Бидэнд Христээр дамжуулан Бурханд хандах тийм бат итгэл байдаг. 5 Бид ямар нэгэн юмыг өөрсдөөсөө гаргадаг юм шиг шаардаж чадахгүй. Харин бидний чадвар Бурханаас гардаг юм. 6 Тэр биднийг үсгээр бус, харин Сүнсээр шинэ гэрээний үйлчлэгчид байх чадвартай болгожээ. Учир нь үсэг бол хөнөөдөг, харин Сүнс бол амь өгдөг аж. (2 КОРИНТ 3:4 – 6)

Бүтээгч Бурхан амийг өгдөг бөгөөд энэ нь мөнх амь ба мөнхийн шагналыг авахын төлөөх боломж юм.

ДЭЛХИЙН МЭДЛЭГЭЭР МӨНХИЙН АМИЙГ ОЛЖ ЧАДАХ УУ?

СУРАЛЦААГҮЙ НЭГЭНИЙ ЭНЭХҮҮ АСУУЛТАНД ТА ХАРИУЛЖ ЧАДАХ УУ?

3 Би мэргэн ухаанд ч суралцсангүй.
Ариун Нэгэний тухай мэдлэг ч надад
алга.

4 Хэн тэнгэр өөд одоод бууж ирэв ээ?
Хэн салхийг гартаа атгаж байв аа?

Хэн усыг дээлэндээ ороож чадав аа?
Хэн дэлхийн хамаг хязгаарыг бүтээв
ээ?

Түүний нэр болон Хүүгийнх нь нэр хэн
бэ? Та мэдэх үү?

5 Бурханы үг бүр соригдсон. Тэрээр
Өөрийнх нь дотор хоргодогсдод
бамбай юм.

6 Түүний үгэн дээр бүү нэм. Тэгвээс
Тэр чамайг буруутгаж, чи худалч
болох вий. (СУРГААЛТ ҮГС 30:3 – 6)

ЭНЭ ДЭЛХИЙД ЯАГААД ТҮМЭН АСУУДАЛ БАЙНА ВЭ?

Энэ дэлхий одоо бол бүтээн байгуулалт нь дуусаагүй барилгын талбай лугаа юм.

Төгс бүтээлийг олж хараад хэтийн төлөвийг мэдэж аваарай

10 Тун удахгүй хорон санаатан үгүй болно. Чи түүний байх газрыг анхааралтай хайх боловч Тэр байхгүй байх болно. (ДУУЛАЛ 37:10)

17 Харагтун, Би шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээнэ. Урьдын юмс санагдахгүй, бодол санаанд ч үл бууна.

18 Харин Миний бүтээх зүйлд үүрд баярлан баясагтун. Харагтун, Би баяр хөөрийн төлөө Иерусалимыг, баяслын төлөө түүний ард түмнийг бүтээнэ.

19 Мөн Би Иерусалимд баярлан, Өөрийн ард түмэнд баясаж байна. Тэгээд тэнд уйлах, орилох дуу цаашид сонсогдохгүй. 20 Тэнд цөөхөн хоног амьдардаг нялхас ч, өөрийн өдрүүдийг гүйцээгээгүй хөгшид ч байхгүй болно.

Зуу наслаад үхэх хүнийг залуу, зуу нас хүрээгүй нэгнийг хараагдсан хүн гэж тооцох болно.

21 Тэд гэр барьж, түүн дотроо сууна. Тэд бас усан үзэм тариалж, үр жимсийг нь иднэ.

22 Тэд барихгүй, өөр хүн сууна. Тэд тарихгүй, бусад нь иднэ. Харин Миний ард түмний өдрүүд нь модны амьдрах хугацаа шиг болох бөгөөд Миний сонгосон хүмүүс өөрсдийнхөө гарын бүтээлийг өмсөнө.

23 Тэд дэмий хоосон ажиллахгүй, зовохын тулд хүүхэд төрүүлэхгүй. Учир нь тэд ба тэдний үр удам нь ЭЗЭНээр ерөөгдсөн хүмүүсийн хойч үе билээ.

24 Тэднийг дуудахаас өмнө Би хариулж, тэднийг ярьж байхад нь Би сонсох цаг ирнэ.

25 Чоно хургатай хамт бэлчин, арслан үхэр мэт сүрэл идэж, шороо нь могойн хоол болно. Тэд Миний бүх ариун ууланд ямар ч муу, хор хөнөөл үйлдэхгүй” гэж ЭЗЭН айлдаж байна. (ИСАИА 65:17 - 25)

ХАРАГДАХГҮЙ ХААНЧЛАЛ НЬ ИЛЭРХИЙЛЭГДСЭН

Есүс бидэнд сүнслэг хаанчлалыг илэрхийлж өгсөн

10 Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. (ИОХАН 10:10)

24 Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ. 25 Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. 26 Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. 27 Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа гэв. (МАТАЙ 7:24 – 27)

12 Хүнд зөв мэт санагдавч төгсгөл нь үхэл уруу хөтөлдөг зам байдаг. (СУРГААЛТ ҮГС 14:12)

15 Мунхгийн зам өөрийнх нүдэнд нь зөв харагддаг. Харин мэргэн нэгэн зөвлөгөөг сонсдог юм. (СУРГААЛТ ҮГС 12:15)

Сонголт минийх байж болох ч үр дагавар нь надаас хамаарахгүй. Хулгайч миний сэтгэл зүрхнээс Үгийг хулгайлснаар аливааг өөрийнхөөрөө хийхэд хүргэдэг.

ЕСҮС ХРИСТИЙН ЗАГАЛМАЙГ ТА ХЭРХЭН ХАРДАГ ВЭ?

ТА ЯМАР СҮНСТЭЙ ВЭ?

Бардам- Загалмай нь мунхаглал

Шашинлаг- Загалмай нь бүдрүүлэх чулуу

Даруу бөгөөд гэмшсэн- Авралын төлөөх Бурханы хүч

18 Загалмайн үг нь мөхөгсдийн хувьд мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн. 19 Учир нь “Би мэргэдийн мэргэн ухааныг устгана. Ухаантнуудын ухааныг Би хэрэгсэхгүй” гэж бичигдсэн байдаг. (1 КОРИНТ 1:18 – 19)

4 Энэ үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын сайн мэдээний гэрлийг үзэж чадахгүй болжээ. (2 КОРИНТ 4:4)

15 Мөнх амьдрагч Түүний нэр нь Ариун бөгөөд өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн үүнийг айлдав. “Би дорд нэгний сүнсийг сэргээж, гэмшсэн нэгний зүрхийг амьдруулахын тулд гэмшсэн болон даруу сүнстэй хүмүүстэй хамт өндөр, ариун газарт оршдог.(ИСАИА 57:15)

*Нэг удаа үхэх нь хүмүүст тогтоогдсон.
Үүний дараа шүүгдэхийн адил,*

(ЕВРЕЙ 9:27)

*Хэрэв бүтээсэн зүйл нь мөнхөд оршихгүй
бол энэ нь салхи дээгүүр нь үлээхэд алга
болдог талын сараан цэцэг шиг юм:
Хоосон, хоосон, хоосон, дэмий хоосон юм .*

*2 Номлогч, “Бүгд хоосон, хоосны хоосон
болой” гэв. 3 Наран доор ажиллагч
хүмүүний бүх хөдөлмөрийн үр ашиг нь юу
вэ? 4 Нэг үеийнхэн явж нөгөө үеийнхэн
ирсээр байвч Дэлхий ертөнц үүрд үлддэг. 5
Түүнчлэн нар мандсаар, жаргасаар,
Хаанаас манддаг тэр л газар уруугаа
яарсаар байх ажээ. 6 Салхи өмнө зүгт
үлээж, тэгснээ хойд зүг уруу эргэж, Улмаар
өөрийн тойргоороо дахин давтан эргэлдэх
ажгуу. 7 Бүх гол далайд цутгавч, далай нь
дүүрдэггүй. Дахин буцаж урсахын тулд
хаанаас эхэлсэн тэр газартаа голууд
буцаж урссаар байдаг.*

8 Хүн үүнийг хэлэхийн аргагүй бүх зүйл залхмаар Нүд харснаараа ханасангүй, чих сонссоноороо дүүрсэнгүй. 9 Юу байсан, тэр нь байх болно. Юу хийгдэж байсан, тэр мөн л хийгдэх болно. Иймээс наран доор шинэ юм юу ч алга. 10 Хэн нэг нь ямар нэг юмыг “Үүнийг хараач, энэ шинэ зүйл байна” гэж магад. Тэр нь хэдийн биднээс өмнө байсан зүйл юм. 11 Өнийн юмс дурсагдахгүй, хожим болох юмс ч ирэх үеийнхний санаанд үл үлдмөй.

(НОМЛОГЧИЙН ҮГС 1:2-11)

Мөнх амийн тухай мэдлэг нь харах мэлмий, сонсох сонор бүхий даруу,гэмшсэн сүнстэй хүмүүст боломжтой юм.

Хэрэв бүтээсэн зүйл (миний хийсэн)нь салхи салхилахад (үхэлтэй тулахад)мөнхөд оршихгүй бол энэ нь хоосноос хоосон юм.

БУРХАН АЙЛДАХДАА

Дэлхий ертөнцийг бүтээгээгүй Бурханд итгэдэг бол

11 Чи тэдэнд “Тэнгэрүүд ба газрыг бүтээгээгүй бурхад газар дэлхийгээс болон тэнгэрүүдийн доороос устах болно” гэж хэл. 12 Өөрийн чадлаар газар дэлхийг бүтээсэн, Өөрийн мэргэн ухаанаар ертөнцийг тогтоосон нь Тэр билээ. Өөрийн ухаанаараа Тэрээр тэнгэрүүдийг өргөсгөсөн.

(ИЕРЕМИА 10:11 – 12)

1 Яагаад үндэстнүүд уурандаа шатаж, Ард түмнүүд дэмий хуйвалдана вэ? 2 Газар дэлхийн хаад бат зогсож, Удирдагчид хоорондоо зөвлөлдөж, ЭЗЭН ба Түүний Тослогдсон Нэгэнийг эсэргүүцэн, 3 “Бид тэдний гинжийг тасалж, Хүлгийг нь өөрсдөөсөө зайлуулцгаая” гэж тэд хэлэв. 4 Тэнгэрт залрагч инээж, Тэднийг Эзэн тохуурхаж байна. 5 Тэгээд Тэр тэдэнд Өөрийн уураар айлдаж, Өөрийн хилэнгээр тэднийг айлган, 6 “Миний ариун уул Сионд Би Өөрийн хааныг өргөмжилсөн” гэнэ. 7 “Би ЭЗЭНий зарлигийг тунхаглана. Тэр надад хэлэхдээ «Чи бол Миний Хүү, Өнөөдөр Би Чамайг төрүүлсэн. 8 Надаас гуй! Би үндэстнүүдийг Чиний өв болгон, Дэлхийн хязгааруудыг ч Чиний эзэмшил болгон өгнө. 9 Чи тэднийг төмөр таягаар хэмх цохиж, Шавар сав шиг бутлах болно» гэсэн”. (дуулал 2:1 – 9)

16 Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. 17 Тэнгэрээс —Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа. (МАТАЙ 3:16 – 17)

ЕСҮС АЙЛДАХДАА

ЧУХАЛ МЭДЛЭГ

29 Есүс —Эхнийх нь “Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. (МАРК 12:29)

13 Есүс —Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. 14 Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно гэхэд, (ИОХАН 4:13 – 14)

3 Есүс хариуд нь —Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд 4 Никодем Түүнд —Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ. 5 Есүс —Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. 6 Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. 7 “Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд бүү гайх. 8 Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав. (ИОХАН 3:5 – 8)

ДЭЛХИЙ ДЭЭР БАЙХДАА ЕСҮСИЙН ХИЙСЭН ЭЦСИЙН ЗАЛБИРАЛ

1 Ингэж хэлээд, Есүс тэнгэр өөд мэлмий өргөн —Аав аа, цаг нь ирлээ. Таныг Хүү чинь алдаршуулахын тулд Хүүгээ алдаршуулаач. 2 Таны Надад өгсөн бүх хүнд Хүү чинь мөнх амийг өгөхийн тулд бүх махан биеийг захирах эрхийг Та Надад өгсөн билээ. 3 Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.

(ИОХАН 17:1 – 3)

МӨНХ АМИЙН ТӨРӨЛТ

АРИУН СҮНС ТАНЬТАЙ ЯРЬДАГ

16 Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. 17 Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ. 18 Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн ялагдсан. Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрэнд итгээгүй юм.

(ИОХАН 3: 16 -18)

–Есүс Христ бол Эзэн гэдгийг амаараа хүлээн зөвшөөрч Тэрээр таны гэм нүглийн төлөө загалмай дээр цовдлогдож үхээд үхлээс дахин амилсан гэдгийг та зүрх сэтгэлдээ итгэж байна уу?

Тийм бол таньд Ариун Сүнс нөлөөлж байгаа юм.

8 Харин энэ нь юу хэлдэг вэ? «Үг нь чамд ойр байна. Чиний аманд, чиний зүрх сэтгэлд бий» гэдэг. Энэ нь бидний тунхаглаж буй итгэлийн үг юм. 9 Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. 10 Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.

(РОМ 10:8 – 10)

Өөрийн сэтгэл хөдлөл, мэдрэмжинд биш Сударт итгэ. Есүс Христ бол Эзэн гэдгийг амаараа хүлээн зөвшөөрч Тэрээр таны гэм нүглийн төлөө загалмай дээр цовдлогдож үхээд үхлээс дахин амилсан гэдгийг та зүрх сэтгэлдээ итгэ байна уу?

71 –р хуудсыг үзээд итгэлээ илэрхийл.

ТАНЫ ЗҮРХ СЭТГЭЛД БУРХАН ХҮРСЭН.

Бурханы Үг (мөнхийн хууль- хуулийг Бурхан өгсөн учраас хэзээ ч өөрчлөгддөггүй):

Таны зүрх сэтгэлд Мөнхийн Бурхан- Ариун Сүнс хүрсэн.

3 Тиймээс хэн ч Бурханы Сүнсээр “Есүс хараагдсан” гэж ярихгүй бөгөөд Ариун Сүнсээр бус бол өөр хэн ч “Есүс бол Эзэн” гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье. (1 КОРИНТ 12:3)

ТА СҮНСЭЭРЭЭ ШИНЭЭР ТӨРЛӨӨ- ДАХИН ТӨРЛӨӨ.

23 Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дамжуулан дахин төрсөн билээ.

(1 ПЕТР 1:23)

САЙН МЭДЭЭ

СУДАРТ ӨГҮҮЛСЭНЧЛЭН

САЙН МЭДЭЭ нь Есүс Христ- Аврагч- Үг ирээд загалмай дээр цовдлогдон үхлээс дахин амилсан гэж Сударт бичигдсэн байдаг.

17 Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө. 18 Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм гэв.

(ИОХАН 10:17 – 18)

ӨӨРТ БАЙГААГАА МЭД

Есүс миний гэмийн төлөө бүх төлөөсийг загалмай дээр төлсөн.

Загалмай дээрх Есүс Христийн золиосоор (нүглийн төлөөс) таны гэм нүгэл уучлагдах боломжтой болсон бөгөөд Бурханы хуулиудын бүхий л шаардлага биелэгдэж, бидний эсрэг дайсны (үхлийн) хүч чадал тэрхүү Загалмай дээр залгигдсан.

1 Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. 2 Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. (ром 8:1 – 2)

3 Харин эдгээр тахил жилээс жилд нүглийн сануулга болдог. 4 Учир нь бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм. 5 Тиймээс Тэр ертөнцөд ирэхдээ “Та өргөл ба тахилыг хүсээгүй, Харин Та Надад бие бэлдсэн.

Нүглийн төлөөх бүх шатаалт тахил ба өргөлийг Та таалаагүй. 7 Тэгээд Би «Үзэгтүн. Бурхан минь, Таны хүслийг үйлдэхээр Би ирлээ. Миний тухай хуйлмал номд бичигдсэн» гэж хэлсэн” гэв. 8 Дээрхийг хэлэхдээ “Тахил ба өргөл, нүглийн төлөөх бүх шатаалт тахил ба өргөлийг Та хүсээгүй. Та тэднийг таалаагүй. (Эдгээр нь Хуулийн дагуу өргөгддөг)” гэсэн. 9 Дараа нь Тэр “Үзэгтүн. Таны хүслийг үйлдэхээр Би ирлээ” гэж айлдав. Тэр хоёрдахийг нь тогтоохын тулд анхныхыг нь зайлуулдаг. 10 Энэхүү хүслээр бид Есүс Христийн нэг удаа бүгдийн төлөө биеэ өргөсөн өргөлөөр дамжуулан ариусгагдсан юм. (ЕВРЕЙ 10:3 – 10)

11 Тахилч болгон өдөр бүр үйлчлэн, нүглийг хэзээ ч зайлуулж үл чадах өнөөх л тахилуудаа дахин дахин өргөсөөр зогсдог. 12 Харин Тэр үүрд нүглийн төлөө нэг тахилыг өргөөд, Бурханы баруун гарт заларсан бөгөөд 13 Өөрийнх нь дайснуудыг хөлийнх нь гишгүүр болгох хүртэл тэр үеэс хойш хүлээж байна. 14 Учир нь Христ ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ. 15 Ариун Сүнс бидэнд мөн гэрчилдэг. Учир нь Тэр 16 “Эзэн айлдаж байна. «Тэр өдрүүдийн дараа тэдэнтэй байгуулах Миний гэрээ энэ юм. Би Өөрийн хуулиудыг тэдний зүрхэнд тавина. Би эдгээрийг тэдний ухаан санаанд бичнэ» гээд, (ЕВРЕЙ 10:11 – 16)

ТАНЫ БҮХ НҮГЭЛ ӨРШӨӨГДӨЖ ЦАГААТГАГДАНА

17 цааш нь «Би цаашид тэдний нүглүүд, Тэдний хууль бус явдлыг санахгүй» гэжээ.

18 Эдгээр зүйлсийн уучлал байгаа газар нүглийн төлөөх тахил цаашид байхгүй болдог. (ЕВРЕЙ 10:17-18)

11 Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. (ИЛЧЛЭЛТ 12:11)

ТАНЫ НЭР АМИЙН НОМД БИЧИГДЭНЭ

11 Цагаан өнгөтэй агуу их сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар олдсонгүй. 12 Үхсэн их бага хүмүүс сэнтийн өмнө зогсож байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв. 13 Тэнгис дотроо байсан үхэгсдийг гаргаж өгөв. Үхэл ба Үхэгсдийн орон өөрсдийн доторх үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэг бүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв.

(илчлэлт 20:11 – 13)

ХОЁР ДАХЬ ҮХЛЭЭС ТА АВРАГДАНА

14 Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. 15 Хэрэв хэн нэгний нэр амийн номд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдсан байна.

(илчлэлт 20:14 – 15)

ТА ОДОО АРИУН СҮНСИЙГ СОНСОЖ

МӨН ДАГАЖ БОЛНО.

1 Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хонины хашаанд үүдээр нь оролгүй, өөр газраар давж ордог хүн бол хулгайч, дээрэмчин мөн. 2 Харин үүдээр нь ордог хүн нь хонин сүргийн хоньчин мөн. 3 Сахиул тэр хүнд үүдийг нээдэг бөгөөд хонин сүрэг түүний дууг сонсдог. Тэр өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж, тэднийг гадагш дагуулж гарна. 4 Тэр өөрийнхийгөө бүгдийг гаргаад, түрүүнд нь явдаг. Хонин сүрэг түүний дууг таньдаг тул түүнийг дагадаг. 5 Тэд гаднын хүнийг ер дагахгүй, харин түүний дууг танихгүй учир түүнээс зугтана гэж айлдав.

(ИОХАН 10:1 – 5)

ХЭНИЙГ ДАГАЖ БУЙГАА ЯЛГАН ТАНИХ

Хулгайч, сайн хоньчны хөлсний хоньчин

6 Есүс энэ сургаалт зүйрлэлээр тэдэнд яривч, Түүний ярьсан нь юу байсныг тэд ойлгосонгүй.

7 Тэгээд Есүс дахин тэдэнд — Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Би бол хонины үүд. 8 [Надаас урьд] ирэгсэд бүгд хулгайч, дээрэмчид юм. Харин хонин сүрэг тэднийг сонсоогүй. 9 Би бол үүд мөн. Хэрэв хүн Надаар орвол, тэр аврагдах болно. Орж, гарч, тэжээлээ олно. 10 Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. 11 Би бол сайн хоньчин мөн. Сайн хоньчин хоньдынхоо төлөө амиа өгдөг. 12 Хөлсний хүн бол хоньчин биш, хонин сүрэг ч түүнийх биш учир чоно ирэхийг хараад тэрээр хонин сүргийг орхин зугтдаг. Чоно хоньдыг цөлмөж, тараадаг.

13 Тэр хөлсний хүн бөгөөд хонин сүрэгт санаа тавьдаггүй тул зугтдаг. 14 Би бол сайн хоньчин мөн. Би Өөрийнхийгөө мэдэх бөгөөд Өөрийнхөн минь Намайг мэднэ. 15 Би Эцэгээ мэдэхийн адил Эцэг минь Намайг мэддэг юм. Би хоньдын төлөө Өөрийн амийг өгнө. 16 Энэ хашаан дахь хонин сүргээс өөр хонин сүрэг Надад бий. Би тэднийг бас авчрах ёстой. Тэд Миний дууг сонсоно. Тэгээд тэд нэг хоньчинтой нэг хонин сүрэг болно.

ИОХАН 10:6 – 16

Хэрэв та Ариун Сүнсний дуу хоолойг дагахгүй бол таньд итгэлийн нотолгоо үгүй.

Итгэлийн үндсээ шалгаад даруу болон гэмшсэн сүнстэй эсэхээ бодолцоно уу?

Зүрх сэтгэл тань зовлонтой бол итгэлийн үндсээ эргэн хараад залбирахдаа дараах зүйлсийг хэлээрэй.

1. Есүс Христ бол миний цорыганц аврагч

2. Есүс Христ бол Бурханы Хүү гэдэгт би итгэдэг.

3. Есүс Христ бол онгон Маригаас мэндэлсэн гэдэгт би итгэдэг.

4. Есүс Христ бол намайг гэм нүглээс чөлөөлөхийн тулд загалмай дээр цовлогдсон гэдэгт би итгэдэг.

5. Есүс Христ дахин амилсан шиг би ч мөн дахин амилах болно гэдэгт би итгэдэг.

6. Есүс Христ мөнхийн улс руу явсан ба мөнхөд амьд гэдэгт би итгэдэг.

7. Есүс Христ дахин ирж Библи дээр бичигдсэн бүх амлалтаа биелүүлнэ гэдэгт би итгэдэг.

8. Амьд ба үхэгсдийн аль альныг Бурхан шүүх бөгөөд Тэрээр үүрд захирах болно.

9. Түүний дахин ирэлтийг би хүлээдэг.

10. Есүс Христ амласныхаа дагуу Ариун Сүнсийг илгээсэн гэдэгт би итгэдэг.

2

ШИНЭ АМЬДРАЛААР АМЬДАРЧ ӨСӨХ

12 *Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа.* 13 *Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн.* 14 *Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ!* 15 *Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна.* 16 *Есүс Би чуулгануудын төлөө та нарт эдгээр зүйлийг гэрчлэхийн тулд Өөрийн тэнгэр элчийг илгээлээ. Би бол Давидын Удам ба Үндэс, гэрэлт үүрийн цолмон билээ гэв.* 17 *Сүнс болон сүйт бүсгүй —Ирээрэй гэнэ. Сонсогч нь —Ирээрэй гэж хэлэг. Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг.*

(Илчлэлт 22:12 – 17)

ШИНЭ АМЬДРАЛААР АМЬДАРЧ ӨСӨХ

СҮНСИЙГ ШАЛГАХ

1 Хайртууд минь, сүнс болгонд бүү итгэ. Харин тэднийг Бурханаас ирсэн эсэхийг мэдэхийн тулд сүнснүүдийг шалга. Учир нь олон хуурамч эш үзүүлэгчид дэлхийд гарсан байна. 2 Бурханы Сүнсийг та нар үүгээр мэднэ. Есүс Христ махан биеэр ирснийг хүлээн зөвшөөрөгч сүнс бүр Бурханаас ирсэн бөгөөд 3 Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй сүнс бүр Бурханаас ирээгүй. Энэ бол Христийг эсэргүүцэгчийнх бөгөөд та нар түүнийг ирж байна гэдгийг сонссон ба тэр эдүгээ дэлхийд хэдийн байж байна. (1 ИОХАН 4:1 - 3)

15 Есүс бол Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрдөг хэний ч дотор Бурхан байж, тэр Бурханы дотор байна. 16 Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг. Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна. 17 Үүгээр шүүлтийн өдөрт биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг.(1 ИОХАН 4:15 – 17)

53 Есүс тэдэнд —Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. 54 Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. 55 Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн. 56 Миний махыг идэж, цусыг уусан хүн Миний дотор байж, Би ч түүний дотор оршин байна. 57 Амьд Эцэг маань Намайг илгээсэн бөгөөд Би Эцэгээр амьдрахын адил Намайг идэгч хүн мөн Надаар амьдарна. 58 Тэнгэрээс бууж ирсэн талх бол энэ мөн. Гэхдээ та нарын өвөг дээдэс идсэн, нас барсантай нь адилгүй, энэ талхыг идсэн хүн мөнхөд амьдарна гэлээ. (ИОХАН 6:53 – 58)

63 Сүнс бол амь өгдөг, мах бол ашиггүй юм. Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ. (ИОХАН 6: 63)

ЭНЭ ДЭЛХИЙГЭЭС АГУУ НЬ ТАНЫ ДОТОР БИЙ

4 Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс аугаа. 5 Тэд бол ертөнцийнх. Тиймээс тэд ертөнцийнхийг ярьдаг. Ертөнц тэднийг сонсдог. 6 Бид бол Бурханых. Бурханыг мэддэг хүн биднийг сонсдог. Бурханых биш хүн биднийг сонсдоггүй. Үүгээр бид үнэний сүнс ба мэхлэлийн сүнсийг мэднэ.

(1 ИОХАН 4:4 – 6)

1 Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. 2 Тэр эхэнд Бурхантай хамт байсан. 3 Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. 4 Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. 5 Гэрэл харанхуйг гийгүүлэхэд, харанхуй түүнийг дийлсэнгүй.

(ИОХАН 1:1 – 5)

12 Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно. 13 Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. 14 Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ.

(ИОХАН 14:12 - 14)

7 Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. 8 Гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ.

(МАТАЙ 7:7–8)

21 Хайртууд минь, хэрэв зүрх маань биднийг яллахгүй бол бид Бурханы өмнө зоригтой байж, 22 гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахиж, Түүний мэлмийд тааламжтай зүйлсийг үйлддэг билээ. 23 Бид Түүний Хүү Есүс Христийн нэрд итгэж, Түүний бидэнд тушаасан ёсоор бие биеэ хайрлах нь Түүний тушаал юм. 24 Түүний тушаалуудыг сахигч нь Түүний дотор байж, Тэр түүний дотор байна. Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр дамжуулан бид мэддэг.

(1 ИОХАН 3:21 – 24)

ХРИСТ ДОТОР ШИНЭ АМЬДРАЛЫГ СУДЛАЖ ӨСӨН ДЭВЖ

Нялх хүүхэд сүүг хүсдэг.

23 Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр ᠔ 2 үгийн цэвэр сүүг нялх хүүхдүүд адил хүсэн тэмүүл. Ингэснээр та нар үүгээр авралд хүртлээ өсөх юм. 24 Учир нь “Бүх махан бие болбоос өвс мэт бөгөөд Бүхий л алдар нь өвс ногооны цэцэг мэт. Өвс ганддаг, цэцэг унадаг. 25 Харин Эзэний үг мөнхөд оршино”.

1 Тиймээс та нар бүх л өс хонзон, заль мэх, хоёр нүүр гаргах явдал, атаа жөтөө болон гүтгэлэг бүхнийг хаяж, 2 үгийн цэвэр сүүг нялх хүүхдүүд адил хүсэн тэмүүл. Ингэснээр та нар үүгээр авралд хүртлээ өсөх юм. 3 Хэрэв та нар үнэхээр Эзэний энэрлийг амссан юм бол тэг.

(1 ПЕТР1:23- 2:3)

ӨДӨР БҮР СҮНСЭЭР ӨСӨХ (ИДЭХ БА УУХ)

56 Миний махыг идэж, цусыг уусан хүн Миний дотор байж, Би ч түүний дотор оршин байна. 57 Амьд Эцэг маань Намайг илгээсэн бөгөөд Би Эцэгээр амьдрахын адил Намайг идэгч хүн мөн Надаар амьдарна. 58 Тэнгэрээс бууж ирсэн талх бол энэ мөн. Гэхдээ та нарын өвөг дээдэс идсэн, нас барсантай нь адилгүй, энэ талхыг идсэн хүн мөнхөд амьдарна гэлээ.

(ИОХАН 6:56 - 58)

Түүний Биеийг иднэ гэдэг нь Бурханы Үгийг уншиж бясалгах гэсэн утга бүхий бөгөөд цусыг ууна гэдэг нь загалмай дээр Есүс цусаараа миний гэм нүглээс чөлөөлөх боломжтой болсон гэдэг зүрх сэтгэлдээ итгэхявдал юм.

Итгэл нь Бурханы Үгийн итгэн сонсохоос ирдэг. Энэ нь итгэлийн нууц юм.

ӨДӨР ТУТМЫН САНУУЛГА БА ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

ДЭЛХИЙЛЭГ МЭДЛЭГ

1. Хоосон (Номлогчийн үгс 1:2), Амьдарч биш сүйрч буй энэ дэлхий нь Үгэн (Иох 1:1-5) дотор бичигдсэн мөнх байдлыг хэзээ ч ойлгохгүй.

2 Номлогч, “Бүгд хоосон, хоосны хоосон болой” гэв.

(НОМЛОГЧИЙН ҮГС 1:2)

1. Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. 2 Тэр эхэнд Бурхантай хамт байсан. 3 Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. 4 Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. 5 Гэрэл харанхуйг гийгүүлэхэд, харанхуй түүнийг дийлсэнгүй.

(ИОХАН 1:1 – 5)

2. Түр зуурын мэдлэг (1 Кор 1:18-23) нь мөнхийн зүйлийг ойлгодоггүй. Учир нь энэ нь тэдний тэдний ойлголтоос хэтэрсэн зүйл юм. Сонсох сонор үгүй.

18 Загалмайн үг нь мөхөгсдийн хувьд мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн. 19 Учир нь “Би мэргэдийн мэргэн ухааныг устгана. Ухаантнуудын ухааныг Би хэрэгсэхгүй” гэж бичигдсэн байдаг. 20 Мэргэн хүн хаана байна? Хуулийн багш хаана байна? Энэ үеийн маргалдагч хаана байна? Бурхан энэ ертөнцийн мэргэн ухааныг мунхаг болгоогүй гэж үү? 21 Учир нь Бурханы мэргэн ухааны тухайд, ертөнц өөрийн мэргэн ухаанаар Бурханыг таньж мэдсэнгүй. Иймд тунхагласан мэдээний мунхаглалаар итгэгчдийг аврах нь Бурханд тааламжтай байсан юм. 22 Учир нь иудейчүүд нь тэмдгийг хүсдэг, грекчүүд нь мэргэн ухааныг хайдаг. 23 Гэвч бид цовдлогдсон Христийг тунхагладаг. Энэ нь иудейчүүдэд бүдрүүлэх саад, харь үндэстнүүдэд мунхаглал болдог агаа д
(1 КОРИНТ 1:18 – 23)

3. Нөхцөл байдалд тулгуурласан мэдлэг нь туйлын мэдлэгийг ойлгож чаддаггүй. (Иса 40:6-8, Дуу 102:25-29)

6 Нэгэн дуу “Дуудагтун” гэсэнд би “Би юуг дуудах вэ?” гэж хариулав. Бүх махан бие нь өвс бөгөөд түүний бүх сүр жавхлан нь талын цэцэг мэт юм. 7 ЭЗЭНий амьсгал дээрээс нь үлээвэл өвс хатаж, цэцэг гандана. Хүмүүс үнэхээр өвс юм. 8 Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно.

(ИСАИА 40:6 – 8)

25 Та эрт үед газар дэлхийн суурийг тавьсан. Тэнгэрүүд ч Таны гарын бүтээл юм. 26 Тэд ч сөнөнө, харин Та мөнх оршино. Тэдгээр нь бүгд өмсгөл шиг элэгдэнэ. Хувцас шиг Та тэднийг солих бөгөөд тэд ч солигдоно. 27 Гэвч Та хэвээрээ болоод Таны он жилүүд төгсөхгүй. 28 Таны зарц нарын үр хүүхдүүд үргэлжлүүлэн амьдарч, Тэдний үр удмууд Таны өмнө бат зогсоно” гэдэг.

(ДУУЛАЛ 102:25 – 28)

4. Бүтээн байгуулалтын талбар нь төслийн төгс зураг биш юм. Тэрхүү төгс зураг нь гэм нүгэл байхгүй байх болох дүр зураг юм. (дуулал 37:9-10, ИСАИА 65:24 – 25)

9 Бузар мууг үйлдэгчид таслагдана, Харин ЭЗЭНийг хүсэн хүлээгчид газар нутгийг өвлөх болно. 10 Тун удахгүй хорон санаатан үгүй болно. Чи түүний байх газрыг анхааралтай хайх боловч Тэр байхгүй байх болно. (дуулал 37:9 – 10)

24 Тэднийг дуудахаас өмнө Би хариулж, тэднийг ярьж байхад нь Би сонсох цаг ирнэ. 25 Чоно хургатай хамт бэлчин, арслан үхэр мэт сүрэл идэж, шороо нь могойн хоол болно. Тэд Миний бүх ариун ууланд ямар ч муу, хор хөнөөл үйлдэхгүй” гэж ЭЗЭН айлдаж байна.

(ИСАИА 65:24 – 25)

МӨНХИЙН МЭДЛЭГ (Бодол санаандаа мэдэх) Евр 11:6

1. *Үсэг, бичиг (цагаан толгойн үсэг) нь хөнөөдөг, харин Сүнс бол амь өгдөг. Ариун сүнсний заасны дагуу ойлгож чадаагүй бол Библи нь зүгээр үсэг юм. (2 Кор 3:4-6)*

Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой.

(ЕВРЕЙ 11:6)

4 Бидэнд Христээр дамжуулан Бурханд хандах тийм бат итгэл байдаг. 5 Бид ямар нэгэн юмыг өөрсдөөсөө гаргадаг юм шиг шаардаж чадахгүй. Харин бидний чадвар Бурханаас гардаг юм. 6 Тэр биднийг үсгээр бус, харин Сүнсээр шинэ гэрээний үйлчлэгчид байх чадвартай болгожээ. Учир нь үсэг бол хөнөөдөг, харин Сүнс бол амь өгдөг аж.

(2 КОРИНТ 3:4 – 6)

2. Итгэл нь Бурханы үгийг сонсоноор дамжих итгэлээр ирдэг(Ром 10:17, 1 Иох 4:15-16, Мат 5:8, Иох 10:3-5). РОМ 10:17 Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг.

15 Есүс бол Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрдөг хэний ч дотор Бурхан байж, тэр Бурханы дотор байна. 16 Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг. Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна.

(1 ИОХАН 4:15 – 16)

8 Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханыг харах болно.

(МАТАЙ 5:8)

3 Сахиул тэр хүнд үүдийг нээдэг бөгөөд хонин сүрэг түүний дууг сонсдог. Тэр өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж, тэднийг гадагш дагуулж гарна. 4 Тэр өөрийнхийгөө бүгдийг гаргаад, түрүүнд нь явдаг. Хонин сүрэг түүний дууг таньдаг тул түүнийг дагадаг. 5 Тэд гаднын хүнийг ер дагахгүй, харин түүний дууг танихгүй учир түүнээс зугтана гэж айлдав.

(ИОХАН 10:3 – 5)

3. Бодол санаандаа мэдэж, зүрхэндээ Үг- “объектив үнэнийг” итгэвэл энэ нь “субъектив үнэн”- итгэлтэйгээ холбовол таны гэрчлэл болно.(Евр 4:2)

2 Учир нь сайн мэдээ бидэнд тунхаглагдсаны адил тэдэнд ч бас тунхаглагдсан юм. Гэтэл тэдний сонссон үг тэдэнд тус болсонгүй. Яагаад гэвэл тэр үг сонсогчдын дотор итгэлээр холбогдоогүй ажээ.

(ЕВРЕЙ 4:2)

4. Зүрхээ хамгаал. Учир нь үйлдэл бүхэн тань үүнээс ундрэн гардаг. (Сур.үгс 4:23, Мат 15:18-20)

23 Юуны түрүүнд зүрхээ хамгаал. Учир нь түүнээс амийн булгууд ундрэн гардаг юм.

(СУРГААЛТ ҮГС 4:23)

18 Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг. 19 Зүрхнээс хорон муу бодол, аллага, завхайрал, садар самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь гардаг. 20 Эдгээр нь хүнийг бузарладаг. Харин гараа угаалгүй идэх нь хүнийг бузарладаггүй гэжээ.

(МАТАЙ 15:18 – 20)

ОЮУН БОДОЛДОО ЗУРАГЛА(амьдралыг эргэн хараад төлөвлө)
Сургаал үгс 4:21-27

- 1. (ТОЛГОЙ) Бурханы хүүхэд- хэн гэдгээ мэдэх: дөлгөөн байдал(Эзэн дотор хэн болох, эрх мэдэл, хариуцлага)*
- 2. (БОДОЛ) Үгэнд анхаарлаа хандуулж, хичээнгүйлэн сонсоод дайсан хэзээ, юу, хэрхэн үг зүйлээс төвлөрлийг холдуулж байгааг олох (чухлыг өөрчилж, хийх ёстойгоо үл хийж хүсэхгүй зүйлээ хийх гэх мэт).*
- 3. (ӨДӨР ТУТМЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ) Үгийг ямагт өөрийн хараа болон зүрхэнд байлгах өөрийн тогтолцоотой байх*
- 4. (ХАРИУЦЛАГА) Зүрх сэтгэлдээ бүхий л чадлаараа хичээх*
- 5. (ХЭЛ ЯРИА) Хэлж буй зүйлдээ болгоомжтой байж , заль мэхтэй амыг таних*
- 6. (НҮД) Өмнө буйгаа: зорилго, тодорхой алсын хараа, урт хугацааны хараа зэргээ цэх харах*
- 7. (ЗОВХИ)Хийх зохилтой зүйлээ алхам алхамаар: богино хугацааны төлөвлөгөөгөөр хийх*
- 8. (ХӨЛ) Эргэцүүлэх- ухаалаг суралцагч нь зөвтийн замыг хайж , залбирч, юу өөрчлөгдөж буйг болон өмнө тань юу байж болохыг харгалзан үзнэ. (SWOT , PEST, хяналтыг хийх)*

21 Тэднийг хараанаасаа алдаж болохгүй. Тэднийг өр зүрхэндээ хадгалж яв. 22 Учир нь гэвэл миний үгс бол тэдгээрийг олсон нэгэнд амь бөгөөд Тэр хүний бүх биед эрүүл мэнд юм. 23 Юуны түрүүнд зүрхээ хамгаал. Учир нь түүнээс амийн булгууд ундран гардаг юм. 24 Мэхлэгч амыг цааш тавь. Заль мэхтэй үгсийг өөрөөсөө холдуул. 25 Нүд чинь өмнө байгаагаа цэх хараг. Харц чинь урагшаа эгц тусаг. 26 Хөлийнхөө доорх замыг хар. Тэгвэл бүх зам чинь дайвшгүй байх болно. 27 Зүүн, баруун талын аль уруу нь ч бүү гуйв. Хөлөө хорон муугаас зайлуулж яв.

(СУРГААЛТ ҮГС 4:21 – 27)

ТААЛАЛД НИЙЦСЭН АМЬДРАЛААР АМЬДРАХ

Сургаалт үгс 3:1-10

1. *Бүү март (Амьдралын шинэ хэвэг маягаар амьдрах)
Сургаалт үгс 3:1-10 (Ойлгож ухаарсан Үг сургаалийг өөртөө сануулахын тулд тэмдэглэл хөтлөх)*
2. *Үгийг зүрхэндээ хадгалах*
3. *Нигүүлслээс зуурах*
4. *Өршөөл ба үнэн: Сайн зүйлсийг хэрэгжүүлж сахих. “ 3 Түгээх”-ийг мөрдлөг болгож хэвшүүлэх(Сайн мэдээ түгээх, хүлээж авсан зүйлээ түгээх, хайрыг түгээх)*
5. *Энэрэнгүй байдал, даруу, гэмшсэн сүнсийг гээхгүй байх-ерөөлийн зан чанар. Баяр хөөртэй зүрх сэтгэлээр сайн дураараа үйлдэх (Иса 55:7-11, 57:14-19)*
6. *Бурхан бүх зүйлийг хяналтандаа байлгадаг гэдгийг сана. 1 Э(Их Эзэнээс эмээх), 2Д (Даруй гэмших, даруй дагах), 3Т (түгээх), 4 Р (Залбирал, Дуу 67, Дуу 65, Илч 7, Дуу 103)*
7. *Зохистой өргөлийг өргөх (Талархсан зүх сэтгэлийн тусгай өргөл)нь ерөөлийн үүдийг нээнэ.*
8. *Түүний залруулгыг дуртай хүлээн ав. Бурхан хайрладаг учраас зэмлэдэг. Та өөрт хамаагүй хүүхдүүдийг залруулж зэмлэдэггүй.*

1 Хүү минь, миний сургаалыг бүү март. Чи зүрхэндээ тушаалыг минь сахь. 2 Учир нь өдрүүдийн хийгээд амьд явах он жилүүдийн урт, Амар тайвныг тэд чамд нэмэх болно. 3 Үнэн ба энэрэл чамайг бүү орхиг. Эдгээрийг цээжнийхээ самбарт бичиж, хүзүүгээрээ ороо. 4 Тийнхүү чи Бурханы болоод хүмүүсийн нүдний өмнө таалал хийгээд нэр төрийг олно. 5 Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. 6 Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно. 7 Өөрийнхөө нүдний өмнө бүү мэргэн бай. ЭЗЭНээс эмээж, хорон муугаас эргэ. 8 Энэ нь ясанд чинь шим тэжээл, биенд чинь амин дэм болно. 9 Бүх бүтээгдэхүүнийхээ дээжээр болон эд хөрөнгөөрөө ЭЗЭНийг дээдэл. 10 Тэгвэл агуулах чинь пиг дүүрч, Торхнууд чинь шинэ дарсаар бялхана.

(СУРГААЛТ ҮГС 3:1 – 10)

ҮҮНИЙГ ӨДӨР БҮР ХЭРЭГЖҮҮЛ

Дуулал 91

1.Эзэнд хандан: та бол миний хоргодох газар, миний хамгаалалт, миний итгэдэг Бурхан гэдгийг хэл

2. Эзэний хайранд зүрхээ зориул

3. Түүний нэрийг мэд

1 Хамгийн Дээд Нэгэний халхавчинд оршигч нэгэн Төгс Хүчит Нэгэний сүүдэр дор амьдарна. 2 Би ЭЗЭНд хандан “Миний хоргодох газар, миний бат цайз, Миний итгэдэг Бурхан минь” гэнэ. 3 Учир нь чамайг анчны урхинаас, Бас үхлийн тахлаас авардаг нэгэн бол Тэр юм. 4 Тэр чамайг өдөөрөө хучих бөгөөд Түүний жигүүр дор чи хоргодох болно. Түүний итгэлтэй байдал бол бамбай болон бэхлэлт юм. 5 Чи шөнийн аймшигаас ч, Өдөр исгэрэх сумнаас ч айхгүй. 6 Мөн харанхуйд явагч тахлаас ч, Үд дунд цөлжүүлэх мөхлөөс ч айхгүй.

7 Мянган хүн чиний дэргэд, Түмэн хүн чиний баруун гар талд унавч, Энэ нь чамд халдахгүй. 8 Чи зөвхөн нүдээрээ хараад л Хорон муу хүнд өгөх хариуг үзэх болно. 9 Учир нь чи миний хоргодох газар болох ЭЗЭНийг буюу Хамгийн Дээд Нэгэнийг орших газраа болгосон юм. 10 Ямар ч хор хөнөөл чамд учрахгүй, Ямар ч гамшиг чиний майханд ойртохгүй. 11 Учир нь бүх замд чамайг хамгаалахын тулд Тэр Өөрийн тэнгэр элч нарт чиний талаар тушаал өгнө. 12 Чамайг хөлөө чулуунд цохичих вий гэсэндээ Тэд чамайг гар дээрээ өргөн явна. 13 Чи арслан, наж могойг гишгэж, Залуу арслан, могойг хөлөөрөө дэвсэлнэ. 14 “Тэр Намайг хайрласан учраас Би түүнийг аварна. Тэр Миний нэрийг мэдсэн учраас Би түүнийг өргөмжилнө. 15 Тэр Намайг дуудах бөгөөд Би түүнд хариулна. Саад бэрхшээлтэй үед Би түүнтэй хамт байна. Би түүнийг аварч, хүндлэх болно. 16 Би түүнийг урт амьдралаар хангаж, Түүнд Өөрийн авралыг үзүүлнэ.

ДУУЛАЛ 91:1 – 16

Дуулал 92

- 1. Өглөөд Түүний хайр энэрлийг тунхагла*
- 2. Орой бүр Түүний итгэлтэй байдлыг тунхагла(Унтахаасаа өмнө өнөөдөр өдрийг хэрхэн өнгөрүүлсэнээ дүгнээд шалгахдаа Ариун сүнсийг дагасан эсэх, аливаа зүйлийг итгэл эсвэл хайргүйгээр хийсэн эсэх,гэмших, суралцах, талархлын өргөл өргөх, магтах)*

1 Өө, Хамгийн Дээд Нэгэн, ЭЗЭНд талархлыг өргөн Таны нэрд магтан дуулах нь сайн юм. 2 Өглөө Таны хайр энэрлийг, Шөнөөр Таны итгэлтэй байдлыг 3 Арван утаст ятга болон босоо ятгаар, Ятгын ая дуугаар тунхаглах нь ч сайн. 4 Учир нь ЭЗЭН Та хийсэн зүйлсээрээ намайг баярлуулсан бөгөөд Би Таны гарын үйлсийн улмаас баясгалантайгаар дуулна. 5 Өө, ЭЗЭН, Таны үйлс хичнээн агуу вэ! Таны бодлууд гүн гүнзгий юм. 6 Мунхаг хүн ч мэдэхгүй, Тэнэг хүн ч үүнийг ухаарахгүй. 7 Энэ нь хорон муу хүн өвс шиг соёолж, Гэм бурууг үйлдэгчид бүгд цэцэглэхэд Тэд мөнхөд устгагдахын тулд ч байсан ажгуу. 8 Харин ЭЗЭН Та бол мөнхөд эрхэм дээд юм.

9 Учир нь үзтүгэй ЭЗЭН, Таны дайснууд, Учир нь үзтүгэй, Таны дайснууд сөнөнө. Гэм бурууг үйлдэгчид бүгд тараагдах болно. 10 Харин Та миний эврийг зэрлэг үхрийнх мэт өргөмжилсөн. Би шинэхэн тосоор тослогдсон. 11 Миний нүд дайснууд уруу минь харж, Миний чих миний эсрэг босогч хорон муу хүмүүсийн тухай сонсдог. 12 Зөв шударга хүн далдуу мод шиг цэцэглэж, Ливан дахь хуш мод шиг ургана. 13 ЭЗЭНий өргөөнд суулгагдсан Тэд бидний Бурханы хашаануудад цэцэглэнэ. 14 Тэд хөгширсөн ч жимс гаргана. Тэд шүүслэг ба ногоон байна. 15 Энэ нь ЭЗЭН шулуун шударга гэдгийг тунхаглахын тулд юм. Тэр бол миний хад бөгөөд Түүн дотор шударга бус юм гэж үгүй.

дуулал 92

Илчлэлт 12:11, 17:4, Эфэс 6:12

Илчлэлт нь бид дайсны эсрэг дайнд байгаа бөгөөд тэр дайсан нь хэн болохыг харуулж дайны ялалтыг харуулдаг. (энэхүү баримтлалыг хэрэгжүүл).

- 1. Хурганы цусаар (Таны төлөө хийсэн зүйлд нь итгэ)*
- 2. Үгийн гэрчлэлээр (Үгэнд итгэ)*
- 3. Амьдралын сонгосон хэв маягаар (Христээс, Түүгээр дамжуулан, Христийн төлөө амьдрах шинэ амьдралын баримтлал)*

11 Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм.

(илчлэлт 12:11)

14 Тэд Хурганы эсрэг дайн хийх бөгөөд Хурга тэднийг ялах болно. Учир нь Тэр бол эздийн Эзэн, хаадын Хаан билээ. Түүнтэй хамт байгчид нь дуудагдсан, сонгогдсон, итгэмжит хүмүүс юм гэв.

(илчлэлт 17:14)

12 Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ.

(ЕФЕС 6:12)

Илчлэлт 21:1-8

“Хэтийн зураглал” ыг хараад тэнгэр дэх “Эцэг” бөгөөд таны дотор байгаа Эзэнээс өдөр тутмынхаа хэрэгцээг худалдан авч өөрийн замд дайсны урхинаас болгоомжил.

ЭЦСИЙН ДҮР ЗУРАГ- ХЭТИЙН ЗУРАГЛАЛ

1 Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож, тэнгис байхгүй болов. 2 Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. 3 Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов. —Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж [тэдний Бурхан нь болно]. 4 Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.

5 Сэнтийд Залрагч —Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд — Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв. 6 Тэр надад —Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө. 7 Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно.

(ИЛЧЛЭЛТ 21:1 – 7)

ДАЙСНЫ ҮХЛИЙН ЗАНГАНААС ЗАЙЛСХИЙХ

8 Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв.

(ИЛЧЛЭЛТ 21: 8)

ӨДӨР ТУТМЫНХАА ХЭРЭГЦЭЭГ ХУДАЛДАН АВ

БУРХАНААС ЗАЛБИРЛААРАА ДАМЖУУЛАН

1 “Цангасан хүн бүр ус уруу ирэгтүн. Мөнгөгүй хүн бүр ирж, худалдан авч, идэгтүн. Ирж, мөнгөгүйгээр, үнэгүйгээр дарс, сүү худалдан авагтун. 2 Та нар яагаад талх биш юманд мөнгө зарцуулдаг вэ? Мөн та нар цатгахгүй юманд юунд хөлсөө зарцуулдаг вэ? Намайг анхааралтай сонсож, сайныг нь ид, элбэг хангалуунд өөрийгөө жаргаа.

(ИСАИА 55:1 – 2)

Нигүүлслийн сэнтий рүү дөхөж очоод гуй, хай, тогш: Энэ нь одоо нээлттэй юм.

19 Иймд ах дүү нар аа, бидэнд Есүсийн цусаар, 20 Өөрийн махан бие болох хөшгөөр дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох итгэл байгаа тул, 21 мөн бидэнд Бурханы гэр дэх аугаа Тахилч байгаа тул 22 бузар мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд өөрсдийн зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, үнэн зүрхээрээ ойртон очицгооё. 23 Өөрсдийн найдварын хүлээн зөвшөөрлөө гуйвалгүй бат баримталцгаая. Учир нь Амлагч нь итгэмжит билээ. 24 Бие биеэ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн урамшуулахад анхааръя. 25 Ингэхдээ зарим хүмүүсийн зуршил болсон шиг хамтран цуглахаа болилгүй, харин нөгөө өдөр ойртож буйг харах тусам бие биеэ зоригжуулъя.

(ЕВРЕЙ 10:19 – 25)

НИГҮҮЛСЛИЙН СЭНТИЙ РҮҮ АМЛАСАН ҮГ БА ЕСҮСИЙН НЭРЭЭР ДӨХӨЖ ОЧООД
ЗАЛБИР

12 Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно. 13 Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. 14 Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ.

(ИОХАН 14:12 – 14)

БУРХАН ӨЧИГДӨР Ч ӨНӨӨДӨР Ч ХЭВЭЭРЭЭ

АЛЬФА БА ОМЕГА

8 Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна. (ЕВРЕЙ 13:8)

8 Би бол байгаа болон байсан, мөн хожим ирэх Төгс хүчит Альфа ба Омега гэж Эзэн Бурхан айлдаж байна. (ИЛЧЛЭЛТ 1:8)

ХРИСТ ДОТОР ИТГЭЛЭЭРЭЭ ДАМЖУУЛАН ГҮЙ

7 Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. 8 Гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ. 9 Хүүгээ талх гуйхад чулуу өгдөг хүн та нарын дунд байна уу? 10 Эсвэл, загас гуйхад нь түүнд могой өгөхгүй биз дээ? 11 Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэнгэр дэх Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст илүү сайныг өгөх нь дамжиггүй бус уу? 12 Тиймээс та нар хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүссэнээрээ л өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд. Энэ бол Хууль болоод Эш үзүүлэгчид мөн. (МАТАЙ 7:7–12)

БҮХНИЙГ ҮҮРД МӨНХИЙН СУУРИН ДЭЭР ҮНДЭСЛЭХ

Бурхан хэзээ ч худал хэлдэггүй

19 Бурхан бол худал хэлдэг хүн биш, гэмшин харамсдаг хүний хүү ч биш. Тэрээр айлдчихаад, Тэр түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, Тэр түүнийгээ сайн болгохгүй гэж үү?

(тооллого 23:19)

АЛДААНААСАА БУЦАЖ БОСОХ

1 Израиль аа, өөрийн Бурхан ЭЗЭН уруу эргэ. Учир нь чи өөрийн хууль бус явдлаас болж бүдэрсэн билээ. 2 Өөртөө үгсийг аван ЭЗЭН уруу эргэ. Түүнд хандаж “Бүх гэм бурууг авч хаяад, биднийг нигүүлсэнгүйгээр хүлээн аваач. Тэгвэл бид уруулынхаа үр жимсийг өргөө.

1 Израиль аа, өөрийн Бурхан ЭЗЭН уруу эргэ. Учир нь чи өөрийн хууль бус явдлаас болж бүдэрсэн билээ. 2 Өөртөө үгсийг аван ЭЗЭН уруу эргэ. Түүнд хандаж “Бүх гэм бурууг авч хаяад, биднийг нигүүлсэнгүйгээр хүлээн аваач. Тэгвэл бид уруулынхаа үр жимсийг өргөө.

(ХОСЕА 14:1 - 2)

Энэ нь ӨӨРИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨХ БУРХАНЫ ХҮСЭЛ ЮМ.

15 Хэн нь ч хэн нэгний хорон мууг муугаар хариулахгүй байхад анхаарагтун. Харин үргэлж нэг нэгэндээ болон бүх хүний төлөө сайн зүйл уруу тэмүүлдэг байгтун. 16 Үргэлж баяртай бай. 17 Тасралтгүй залбир. 18 Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 19 Сүнсийг бүү бөхөө. 20 Эш үзүүллэгийг бүү басамжил. 21 Харин бүхнийг шалга, сайныг баригтун. 22 Бузар муугийн алив хэлбэрийг цээрлэгтүн. 23 Амар тайвны Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгаг. Сүнс, сэтгэл, бие тань бидний Эзэн Есүс Христийг ирэхэд бүрэн хамгаалагдсан бөгөөд гэм зэмгүй байх болтугай. 24 Та нарыг Дуудагч нь итгэмжит бөгөөд Тэр мөн үүнийг биелүүлэх болно.

(1 ТЕСАЛОНИК 5:15 – 24)

11 Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм.

(илчлэлт 12:11)

13 Хэрэв миний өнөөдөр чамд тушааж буй ЭЗЭН Бурханыхаа тушаалыг чи сахин үйлдэхийн тулд тэдгээрийг сонсвол ЭЗЭН чамайг сүүл болгохгүй, толгой болгоно. Чи доор орохгүй ямагт дээр нь байна.

(дэд хууль 28:13)

6 Тэр надад —Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө. 7 Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. 8 Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв.

(илчлэлт 21:6 – 8)

Дараах зүйлсийг чангаар хэлнэ үү:

Есүс Христ бол амьд Бурханы Хүү гэдэгт би итгэж байна.

Есүс миний гэмийн төлөө загалмай дээр цовлогон нас барсан гэдэгт би итгэж байна. Бурхан Түүнийг үхлээс амьлуулсан гэдэгт би итгэж байна. Эзэн Есүс минь зүрх сэтгэлд минь орж ирээч. Миний Эзэн, Аваргч болооч гэж урьж байна .

Энэ залбирлын дараа 22 р хуудсын харна уу. Энэ залбирлыг зүрх сэтгэлээсээ хэлснийхээ дараа та Есүс Христийн цусаар худалдан авагдсан Бурханы хүүхэд болох боломжтой болохыг Ариун сүнсээр дамжуулан ойлгох болно.

20 Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.

(илчлэлт 3:20)

Дайсны (буруу урсгалууд гэх мэт) болон “ гэрлийн” гэж харагдах дуу хоолойг ялгаж таних

1. *Сүмийн үндэслэгч нь Есүс Христ мөн.*

Дайснууд Есүсийн нэрийг хэрэглэж өөрсдийгөө Бурханаас илчлэлт хүлээн авсан гэж хэлдэг.

2. *Бурханы үг: Ариун Бичээс нь хэзээ ч өөрчлөгддөггүй. Тэрхүү Ариун Сүнс нь 66 номыг бичүүлж үндсэн бичээсээс зөрөөгүй бичсэн.*

Дайснууд Бурханы бичигдсэн үгэн дээр нэмж, өөрчилж, хасахыг оролддог.

3. *Нэг Бурхан: Тэнгэр, газар ба түүн дэх бүх юмсыг бүтээсэн. Бурханы үгэнд бичигдсэн бүхий л ажлыг гүйцээх.*

Бурхан Эцэг- үл харагдах, Сүнс

Бурханы хүү- харагдах, Бурхан эцэгийг харуулсан

Бурханы Ариун Сүнс- Бурханы хүүхдүүдийн дотор оршдог.

Дайснууд нь Есүс Христ Бурханы Хүү гэдгийг эсвэл Ариун Сүнсийг эсэргүүцдэг.

4. *Хүний шудрага зөвт байдал: Хэн ч Бурханы хаанчлалд орж чадахуйц зөвт биш- гэм нүгэлтэй бөгөөд үхэл ба шүүлт оногддог.*

Дайснууд нь нөхцөл байдалд тохирсон ёс зүй, номлол, учир шалтгаан ба хуулийг баримталдаг. Тэд “Үг”ийг ба шүүлтийг үгүйсгэдэг.

5. *Сайн мэдээ: Бурхан Бичээст хэлсэнийхээ дагуу гүйцэтгэсэн. Есүс судрын дагуу ирж, нас барж, дахин амилсан бөгөөд бичигдсэнийхээ дагуу дахин ирж бичигдсэний дагуу шүүнэ.*

Бурхан судрын дагуу хийснийг болон хийх зүйлийг дайснууд гуйвуулж өөрчилдөг.

6. *Аврал: “ Есүс бол Их Эзэн” гэдгийг хүлээн зөвшөөрч Бурхан Түүнийг үхлээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэсэн нэгнүүдэд аврал зориулагддаг. Есүс Христ бол Их Эзэн гэдэгт итгэсэн бүх хүнд Ариун Сүнс бэлэг болгон өгөгддөг.*

Дайснууд Есүс Христ махан биеэр төрсөн гэдгийг үгүйсгэдэг. Бүгдийн төлөө нэг удаа Есүс биеэ бүрэн өргөл болгож өгсөн гэдгийг тэд гуйвуулж нэмж хасдаг. Тэд авралын тухай ойлголтыг ёс заншлуудаараа хольж байнга нэмдэг. Тэд авралыг авах “ итгэлээр л боломжтой” гэдгийг гуйвуулдаг.

Агуулга

1

ТАНЫ АМЬ СҮНСНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Бурхан яагаад амь сүнсэнд анхаардаг вэ? 5

Эцсийн амьсгал бол сүнсний биш махан биеийн үхэл юм 6

Үсгийг Сүнсээр уншихыг та мэдэх үү? 7

ДЭЛХИЙН МЭДЛЭГЭЭР ҮҮРД МӨНХИЙГ ОЛОХ БОЛОМЖТОЙ ЮУ? 8

Суралцаагүй зүйлийн асуултанд та хариулж чадах уу?

ЭНЭ ДЭЛХИЙД ЯАГААД ТҮМЭН АСУУДАЛ БАЙНА ВЭ?

Хэтийн төлөвийн зураглал 9

ХАРАГДАХГҮЙ ХААНЧЛАЛ НЬ ИЛЭРХИЙЛЭГДСЭН

Есүс бидэнд сүнслэг хаанчлалыг илэрхийлсэн 11

ЕСҮС ХРИСТИЙН ЗАГАЛМАЙГ ТА ХЭРХЭН ХАРДАГ ВЭ?

Та ямар сүнстэй вэ? 13

Хүн бүрт үхэл ирдэг болсон 14

БУРХАН АЙЛДАХДАА

Дэлхий ертөнцийг бүтээгээгүй Бурханд итгэдэг бол 16

Бурхан цорын ганц ХҮҮТЭЙ 17

ЕСҮС ХРИСТ АЙЛДАХДАА

Чухал мэдлэг 18

Дэлхий дээр байхдаа Есүсийн хийсэн эцсийн залбирал 19

МӨНХ АМИЙН ТӨРӨЛТ

АРИУН СҮНС ТАНЬТАЙ ОДОО ЯРЬЖ БАЙНА 20

Таны зүрх сэтгэлд Бурхан хүрсэн. 22

САЙН МЭДЭЭ

Сударт өгүүлсэнчлэн 23

ӨӨРТ БАЙГААГАА МЭД

Есүс миний гэрийн төлөө бүх төлөөсийг загалмай дээр төлсөн. 24

Таны бүх нүгэл өршөөгдөж цагаатгагдах болно 26

Таны нэр амийн номд бичигдэнэ 27

Хоёр дахь үхлээс та аврагдана 28

ТА ОДОО АРИУН СҮНСИЙГ СОНСОЖ

Мөн дагаж болно. 29

ХЭНИЙГ ДАГАЖ БУЙГАА ЯЛГАН ТАНИХ

Хулгайч, сайн хоньчны хөлсний хоньчин 30

2

ШИНЭ АМЬДРАЛААР АМЬДАРЧ ӨСӨХ

Сүнсийг шалгах 35

Христ дотор байх 36

Христ дотор хэрхэн байхыг суралцах 37

Энэ дэлхийгээс агуу нь таны дотор бий 38

Гайхалтай боломж нээгдсэн: Үүрд мөнх 39

ХРИСТ ДОТОР ШИНЭ АМЬДРАЛЫГ СУДЛАЖ ӨСӨН ДЭВЖ

Нялх хүүхэд нь сүүг л хүсдэг. 41

Өдөр бүр сүнсээр өсөх (идэх ба уух) 42

Өдөр тутмын сануулга ба хэрэгжүүлэлт 43

Дэлхийлэг мэдлэг 43

МӨНХИЙН МЭДЛЭГ (Бодол санаандаа мэдэх) 47

ОЮУН БОДОЛДОО ЗУРАГЛА(амьдралыг эргэн хараад төлөвлө) 50

ТААЛАЛД НИЙЦСЭН АМЬДРАЛААР АМЬДРАХ 52

ҮҮНИЙГ ӨДӨР БҮР ХЭРЭГЖҮҮЛ

Дуулал 91 54

Дуулал 92 56

Илчлэлт 12:11, 17:4, Эфэс 6:12 58

Илчлэлт 21:1-8 60

ЭЦСИЙН ДҮР ЗУРАГ- ХЭТИЙН ЗУРАГЛАЛ 60

ДАЙСНЫ ҮХЛИЙН ЗАНГАНААС ЗАЙЛСХИЙХ 62

ӨДӨР ТУТМЫНХАА ХЭРЭГЦЭЭГ ХУДАЛДАН АВ

Бурханаас залбирлаараа дамжуулан 62

Гуй, хай, тогш 63

Есүсийн амласан үг 64

БУРХАН ӨЧИГДӨР Ч ӨНӨӨДӨР Ч ХЭВЭЭРЭЭ

Альфа ба Омега 65

Христ дотор итгэлээрээ дамжуулан гуй 66

БҮХНИЙГ ҮҮРД МӨНХИЙН СУУРИН ДЭЭР ҮНДЭСЛЭХ

Бурхан хэзээ ч худал хэлдэггүй 67

Алдаанаасаа буцаж босох 69

Энэ нь Өөрийн хүүхдийн төлөөх Бурханы хүсэл юм. 69

Ялалтын замаар Бурхан өөрийг тань удирдахыг сонсвол дуулгавартай дага 70

@2021 VIAmission бүх эрх хамгаалагдсан.

Ариун Библи @2004 ишлэлүүдийг “Ариун Библийн Нийгэмлэг”ийн журмын дагуу хэрэглэв.